

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ  
*/2017 он/***

Өлгий хот 2018 он

## Гарчиг

1.Ойлголт тодорхойлолт, судалгааны товч агуулга	4-6
2.Суурин хүн амын насны бүтэц, Хүн ам зүй	7
3. Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүч	8
4.Ажилгүйдлийн үзүүлэлтүүд	9-10
5.Хөдөлмөрийн чадваргүй хүн ам, суралцагчид	11-12
6.Суурин болон хөдөлмөрийн насны хүн ам, хөдөлмөр эрхлэлт	13-14
7.Ажиллагчид,ажиллагсад	15-19
8.Ажиллах хүчний оролцооны түвшин, бүртгэлтэй ажилгүйчүүд	20-23
9.Шинэ ажлын байр,бүтэц	24-25
10. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалт	26-28
11.Дүгнэлт	29
12.Ашигласан ном,материал	30



Танилцуулгыг хянан, тохиосон:

Н.Ерлан

Танилцуулгыг хийж нэгтгэн боловсруулсан:

Ш.Манзелхан

---

Санал хүсэлт байвал доорх  
хаягаар холбоо барина уу.

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс  
Засаг даргын тамгын газрын байр

E-mail: [bayan-ulgii@nso.mn](mailto:bayan-ulgii@nso.mn),  
[manzelkhan@nso.mn](mailto:manzelkhan@nso.mn)

Утас: 70422432 ,70422322  
Интернет хаяг: [//www.nso.mn/bayan-ulgii.nso.mn/](http://www.nso.mn/bayan-ulgii.nso.mn/)

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс  
Өлгий хот, 2018 оны 05-р сар

## Танилцуулгад орсон үзүүлэлтүүдийн ойлголт, тодорхойлолт, тооцсон аргачлал

**Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам** - Үндэсний тооцооны системийн хүрээнд, тухайн цаг хугацаанд бүтээгдхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна. Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч) -ыг *эдийн засгийн байнгын идэвхтэй хүн ам, эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам* гэж хоёр ангилна.

Эдийн засгийн идэвхитэй хүн амыг урт хугацаагаар буюу хуанлийн жилээр хэмжигдэх байнгын идэвхитэй хүн ам, нэг долоо хоног буюу нэг өдрийн хугацаагаар хэмжигдэх тухайн үеийн идэвхитэй хүн ам гэсэн хоёр аргаар тодорхойлдог. Энд орсон ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам нь “байнгын идэвхи” гэсэн ойлголтонд тулгуурласан ба нөгөө талаар Монгол улсын хуулиар тогтоосон хөдөлмөрийн насны хүрээнд багтах хүн ам тул 2000 оны хүн ам, орон сууцны тооллого, Ажиллах хүчний түүвэр судалгааны үед хэрэглэсэн “тухайн үеийн идэвхи”-ээр тодорхойлсон эдийн засгийн идэвхитэй хүн амаас зөрүүтэй учир тоо нь өөр өөр байгаа болно. Хөдөлмөрийн насны ажил эрхлээгүй, халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлгүй хүмүүс, хөдөлмөрийн насны суралцагчид, хугацаат цэргийн албан хаагчид, хоригдол хүмүүс ажиллах хүчинд хамрагдаагүй болно.

**Ажил эрхэлдэг хүн ам буюу ажиллагч** гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг хэв шинж (статус)-д хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ. Аж ахуйн нэгж, байгууллагын орон тоонд ажиллагч, албан бус хөдөлмөр эрхлэгч, гэрээгээр ажил гүйцэтгэгч, улирлын чанартай ажиллагчид, түр ажилтан, бүрэн бус цагаар ажиллагчид мөн ажилтай мөртлөө тодорхой шалтгаанаар (өвчтэй, чөлөөтэй, амралттай г.м) ажиллаагүй хүмүүс хамрагдсан.

**Ажилгүйчүүд буюу ажилгүй иргэн** – Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрийн насны, хөдөлмөрлөх чадвартай, тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.

-“*ажилгүй байсан*” гэж сүүлийн долоо хоногт Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр болон ажил гүйцэтгэх гэрээгээр ямар нэг ажил гүйцэтгээгүй, хувиараа ажил, үйлчилгээ эрхэлж орлого олоогүй байхыг;

-“*ажил хийхэд бэлэн*” гэж Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулахаас татгалзахгүй байхыг;

-“*ажил идэвхтэй хайж байгаа*” гэж ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлж, нэгээс доошгүй удаа ажлын байрны талаар мэдээлэл авсан эсхүл ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих зэрэг ажил олох оролдлого идэвхтэй хийснийг тус тус ойлгоно.

**Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин** – Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхтэй хүн амыг хөдөлмөрийн насны хүн амд харьцуулсан хувь.

**Хөдөлмөр эрхлэлтийн түвшин** – Ажиллагчдын тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулсан хувь.

**Ажилгүйдлийн түвшин** – Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амд харьцуулсан хувь.

**Бүртгэлтэй ажилгүйчүүдийн хувь** – Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амд харьцуулсан хувь.

**Хүн ам зүйн ачаалал** – Хөдөлмөрийн насны нэг хүн амд ногдох хөдөлмөрийн насанд хүрээгүй, хөдөлмөрийн нас хэтэрсэн хүний тоо.

**Хөдөлмөр эрхлээгүй хүн ам** – Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай, хөлсний болон хувиараа хөдөлмөр эрхэлж цалин, хөлс, орлого олдоггүй, хүндэтгэх ба бусад (хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолгүй, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлгүй боловч ажил хайж байгаа, тодорхой шалтгаангүй г.м) шалтгаангаар ажил идэвхитэй эрж хайхгүй байгаа хүн ам. Гэхдээ эдгээрт бүх шатны сургуульд өдрөөр суралцагчид, хугацаат цэргийн албан хаагчид, хоригдол, хөдөлмөрийн насны чадваргүй хүмүүс ороогүй.

**Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүн ам** – Хөдөлмөрийн насны, албан ёсны эрх бүхий байгууллагын нотолгоогоор хөдөлмөрийн чадвараа 6 сараас дээш хугацаагаар түр болон бүрмөсөн алдсан нь тогтоогдсон хөгжлийн бэрхшээлтэй болон холбогдох хуулийн дагуу тэтгэврийн наснаасаа өмнө тэтгэвэр тогтоолгосон (тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа хүн орохгүй) хүмүүс.

**Хөдөлмөрийн насны суралцагчид** – Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай их, дээд сургууль, коллеж, тусгай мэргэжлийн анхан болон дунд шатны сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, 6 сараас дээш хугацаагаар мэргэжлийн сургалтанд хамрагдагчид, ЕБС-д суралцаж буй иргэд орно.

## Оршил

Хүн амын ажил эрхлэлтийн судалгааны үзүүлэлтүүдийг сум, хорооны нутаг дэвсгэрт 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа (Монгол Улсын харьяат, манай улсад удаан хугацаагаар оршин сууж байгаа гадаадын болон цагаач иргэд) суурийн хүн амаар гаргадаг.

Энэхүү судалгаанд аймгийн нийт хүн амын чухам хэдэн хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа, ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам, ажил эрхэлдэг хүн ам буюу ажиллагчид, ажилгүйчүүд, ажил эрхлээгүй хүн амын тоо хэд байгаа, хүн ам зүйн ачаалал, ажиллах хүчний хөдөлмөр оролцоо, ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин ямар байгааг харуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн өгөөжийг тооцож, үнэлэлт дүгнэлт өгч байна. Улсын хэмжээгээр ажил эрхлэлтийн үзүүлэлтүүдийг ажил эрхлэлтийн судалгааны үр дүнгээр тооцож байгаа болохоор зарим үзүүлэлтүүдийн зэрэгцүүлэлт урьд жилүүдийнхээс хэлбэлзэлтэй гарсан болно. Аймгийн түвшинд ХАӨМСангийн үзүүлэлтээр авч байгаа болохоор зарим үзүүлэлтүүд аймаг бүсийн түвшинд ялгаатай гарч байгаа нь судалгаанаас харагдаж байна.

### **Судалгааны товч агуулга**

Энэ судалгааны гол зорилго нь эдийн засгийн идэвхтэй хүн амыг тодорхойлж, түүнээс ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин, ажил эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн түвшинг тооцож зэрэгцүүлэхэд оршино. Эдгээр үзүүлэлтүүдийг аймгийн түвшин, сумуудаар гаргасан. Мөн судалгаанд эдийн засгийн үйл ажиллганы салбар хөдөлмөрийн чадваргүй болон ажил хөдөлмөр эрхлээгүй хүн ам, насны бүлгээр харууллаа.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал нь ажиллах хүчний урсгал хөдөлгөөн ихтэй, ажиллагсдын бүтээмж бага, хөдөлмөрийн үнэлэмж доогуур хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчний өрсөлдөх чадвар хангалтгүй, ажилгүйчүүдийн дүнд мэргэжлийн хүмүүсийн хувь хэмжээ их байгаа зэрэг сөрөг асуудлууд байна.

Аливаа улс орны эдийн засгийн хөгжил, иргэдийнх нь аж байдал, амжиргааны ерөнхий түвшин нь хүн амынхаа ажил эрхлэлтийн түвшинтэй зохих ёсоор холбоотой байдаг. Өндөр боловсролтой, ур чадвартай ажиллах хүч бол тухайн улс орны хөгжлийг тодорхойлогч нэгэн гол хүчин зүйл. Тухайн орны ажиллах хүч, ажил эрхлэлтийн байдал нь хүн амын насны бүтцээс шууд хамааралтай байдаг. Жил бүр хөдөлмөрийн насанд шилжиж байгаа хүний тоо, хөдөлмөрийн наснаас гарч байгаа хүний тооны зөрүү нь хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай хүний цэвэр өсөлтийг харуулна. Хөдөлмөрийн насанд шилжих хүний тоо нь тайлант жилээс 15 жилийн өмнөх төрөлтийн түвшин, нялхсын болон хүүхдийн нас баралтын түвшингээс хамаардаг билээ.

Аймгийнхаа суурин хүн амын бүтцийг 2013-2017 оны байдлаар авч үзвэл 16 хүртэлх насны хүүхдийн дүнд эзлэх хувийн жин 2013,2014,2015 онуудад ижил түвшинд байсан ба 2017 онд 2016 оныхоос 5.9 пунктээр буурч, өндөр настны эзлэх хувийн жин 2017 онд өмнөх оноос 0.2 пунктээр,хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь нь 2017 онд 5.7 пунктээр нэмэгдсэн байна. (Хүснэгт 1)

## Суурин хүн амын насны бүтэц

	2014	2015	2016	2017								
					$\frac{2017}{2014}$	$\frac{2017}{2015}$	$\frac{2017}{2016}$	2014	2015	2016	2017	
Суурин хүн ам - Бүгд	93165	97787	99346	101591	109.0	103.9	102.3	100.0	100.0	100.0	100.0	
Үүнээс:16 хүртэлх настай	33691	36525	42262	37172	110.3	101.8	88.0	36.2	37.4	42.5	36.6	
Хөдөлмөрийн насны /16-59 настай/	54650	56503	52014	59071	108.1	104.5	113.6	58.7	57.8	52.4	58.1	
Хөдөлмөрийн нас хэтэрсэн /60 ба дээш/	4824	4759	5070	5348	110.9	112.4	105.5	5.2	4.9	5.1	5.3	

Суурин хүн амын тоо өмнөх оныхоос 2.3 хувиар нэмэгдэхэд нөхөн үржих насны эмэгтэйчүүдийн тооны өсөлт, хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн сангийн сайжралт, өөр газар суралцаж байгаа оюутанууд тухайн газрын бүртгэлд бүрэн хамрагдаагүй зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөн байна.

Хөдөлмөрийн насны хүн амын тоо 2017 онд 2014 оныхоос 8.1 хувиар, 2015 оныхоос 4.5 хувиар, 2016 оныхоос 13.6 хувиар тус тус өссөн байна. 16-59 насныхан аймгийн хүн амын 58.1 хувийг эзлэж манай аймагт хөдөлмөрийн хангалттай нөөц байгааг харуулж байна.

## Хүн ам зүйн ачаалал

	2014	2015	2016	2017
0-15 насны хүн ам	33691	36525	36354	35203
Хөдөлмөрийн насны хүн ам	54650	56893	52014	59751
Өндөр настаны тоо	4824	4643	5070	6637
<b>Хүн ам зүйн ачаалал</b>	<b>14.32</b>	<b>64.21</b>	<b>69.91</b>	<b>58.93</b>

\*Хүн ам зүйн ачаалал 100 хүнд ногдох

Хүн ам зүйн ачаалал:Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, өндөр настангуудын харьцаагаар илэрхийлэгддэг үзүүлэлт юм.Улс орнууд хүн амынхаа хөгжлийн ирээдүйн хандлагыг урьдчилан тодорхойлохдоо хүн ам зүйн ачааллыг харгалзан үздэг.Манай аймагт хүн ам зүйн ачаалал 2014 онд 61.66, 2015 онд 64.21, 2016 онд 69.91, 2017 онд 58.93 болж 2016 оноос 10.98 пунктээр буурсан байна.

## Хүн ам, хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	хэмжих нэгж	2016		2017		2017 % 2016
		Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	
Хүн амын тоо	тоо	99346	49808	101591	50898	102.3
15 ба түүнээс дээш насны хүн ам	тоо	62992	31854	66388	33499	105.4
Эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо	хүн	43940	20206	51973	23875	118.3
Ажиллагсдын тоо	хүн	39873	17851	46578	20480	116.8
Ажилгүй иргэдийн тоо	хүн	4067	2355	6570	3934	161.5
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо	тоо	1320	592	1207	513	91.4
Эдийн засгийн идэвхигүй хүн амын тоо	хүн	22571	13910	20676	11950	91.6
Ажиллах хүчний оролцооны түвшин	%	66.1	59.2	69.9	66.9	105.7
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	%	59.9	49.8	62.8	56.2	104.8
Ажилгүйдлийн түвшин	%	9.3	11.7	12.4	16.1	133.3

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn

Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтүүдээс харахад хөдөлмөрийн насны хүн амын 86.9 хувь нь эдийн засгийн идэвхитэй хүн байгаа ба тэдний 76.2 хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байна. Хүн амын 34.7 хувийг/35.3 мянга/ хүүхэд, 58.8 хувийг/ 59.7 мянга/ хөдөлмөрийн насны хүн ам, 5.3 хувийг /5.4 мянга/ хөдөлмөрийн нас хэтэрсэн ахмад настай хүмүүс эзэлж байна

Баруун бүсийн аймгуудын хөдөлмөр эрхлэлтийн зарим үзүүлэлтүүдийн зэрэгцүүлэлт /судалгааны үр дүнгээр /

Баруун бүсийн аймгууд	Ажил эрхлэлтийн түвшин				Хөдөлмөр эрхлээгүй хүний тоо			
	2014	2015	2016	2017	2014	2015	2016	2017
Баян-Өлгий	56.2	63.4	59.9	62.7	10425	5869	4067	6570
Увс	65.7	70.1	63.9	66.5	5064	3279	5197	4970
Ховд	61.1	62.8	61.5	61.4	3938	3107	6056	5368
Говь-Алтай	65.3	70.2	66.9	68.8	2717	2403	2667	2436
Завхан	77.3	68.2	65.0	71.2	1501	2218	3839	1507
<b>Улсын дундаж</b>	<b>57.2</b>	<b>56.9</b>	<b>54.5</b>	<b>55.8</b>	<b>95856</b>	<b>92672</b>	<b>127807</b>	<b>119092</b>


Судалгааны үр дүнгээр тооцож гаргасан бүсийн болон улсын дүнгийн тоо мэдээлэлүүд нь аймгийн сумаар гаргасан тооноос ялгаатай байгаа. Судалгааны үр дүнгээр тооцсон ажил эрхлэлтийн түвшингээр баруун бүсийн аймгуудын дотороос хамгийн бага хувийг Ховд аймаг, хамгийн өндөр хувийг Завхан аймаг эзлэж байна. Хөдөлмөр эрхлээгүй хүний тоогоор баруун бүсийн аймгуудаас хамгийн олон хүнтэй нь Ховд аймаг, хамгийн бага хүнтэй Завхан аймаг байна.

**Ажилгүйдлийн үзүүлэлтүүд**  
/ Ажиллах хүчний судалгааны үр дүнгээр /

Аймаг	Ажилгүйдлийн түвшин				Ажилгүйчүүдийн тоо			
	2014	2015	2016	2017	2014	2015	2016	2017
Баян-Өлгий	22.5	11.9	9.3	12.4	10425	5869	4067	6570
Говь-Алтай	10.2	8.8	10.1	8.6	2717	2403	2667	2436
Завхан	4.0	6.9	11.4	4.4	1501	2218	3839	1507
Увс	14.8	8.5	14.2	13	5064	3279	5197	4970
Ховд	11.7	8.6	15.1	13.5	3938	3107	6056	5368
Баруун бус	13.3	9.2	12.1	10.7	23645	16876	21826	20851
Улсад	7.9	7.5	10.0	8.8	95856	92672	127807	119092

2017 оны судалгааны үр дүнг бүсээр авч үзэхэд хамгийн их ажилгүйчүүдтэй аймаг Баян-Өлгий, хамгийн бага ажилгүйчүүдтэй Завхан аймаг байна. Судалгааны үр дүнгээр тооцсон ажилгүйдлийн түвшингээр баруун бүсийн аймагуудаас хамгийн өндөр хувийг Ховд аймаг эзлэж байна. Баян-Өлгий аймагт 2017 оны байдлаар баруун бүсийн ажилгүйчүүдийн 31.5 хувь нь, улсын хэмжээний ажилгүйчүүдийн 5.5 хувь ногдож байна.


**Ажилгүйчүүдийн бүтэц / баруун бүс /**



## Ажилгүй иргэд, хүйс, насны бүлэг, байршлаар

	Бүгд	Хүйс			Байршил					
		Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Хот		Хөдөө			
					Хүйс		Бүгд	Хүйс		
					Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй	
Бүгд	6,570	2,636	3,934	3,247	1,485	1,762	3,322	1,151	2,172	
Нас	15 - 19	284	95	189	146	48	98	138	47	91
	20 - 24	1,802	1,053	749	851	500	351	951	553	398
	25 - 29	2,194	504	1,690	1,169	396	773	1,025	108	917
	30 - 34	733	484	250	286	239	47	447	245	203
	35 - 39	343	92	251	246	47	199	97	45	52
	40 - 44	653	162	492	250	53	197	403	109	294
	45 - 49	312	53	259	150	53	97	163		163
	50 - 54	202	149	54	149	149		54		54
	55 - 59	45	45					45		45

Аймгийн ажилгүй иргэдийн 33.4 хувийг 25-29 насныхан, 27.4 хувийг 20-24 насныхан, 11.2 хувийг 30-34 насныхан эзэлж байгаа бөгөөд нийт ажилгүй иргэдийн 76.3 хувийг 15-34 насны залуучууд эзэлж байна. Залуучуудаас гадна 40-44 насныхан ажилгүйчүүдийн 9.9 хувийг, 4.8 хувийг 45-49 насныхан эзлэж тухайн насны хүмүүсийн хөдөлмөр эрхлэх хүсэлт их байгаа нь харагдаж байна.



### Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүний тоо


Он	Хөдөлмөрийн чадваргүй - Бүгд	2017 онтой харьцуулсан хувь
2012 он	3393	149.6
2013 он	3844	132.1
2014 он	3485	145.7
2015 он	4551	111.6
2016 он	4376	116.0
2017 он	5077	100.0

Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 2017 онд 5077 болж 2012-2016 онуудаас 11.6-49.6 хувиар нэмэгдсэн байна. Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүн амд хөдөлмөрийн насны, зохих журмын дагуу хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан тогтоох комиссын нотолгоогоор хөдөлмөрийн чадвараа 6 ба түүнээс дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан нь тогтоогдсон хөгжлийн бэрхшээлтэй болон холбогдох хуулийн дагуу тэтгэврийн наснаасаа өмнө тэтгэвэр тогтоолгосон (тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа хүн орохгүй) хүмүүсийг хамруулсан.

### Хөдөлмөрийн насны суралцагчдын бүтэц


	2014	2015	2016	2017	$\frac{2017}{2016}$	Бүтэц			
						2014	2015	2016	2017
Эрэгтэй	1931	2382	2402	3431	142.8	46.6	46.2	47.2	51.8
Эмэгтэй	2214	2770	2692	3192	118.6	53.4	53.8	52.8	48.2
Бүгд	4145	5152	5094	6623	130.0	100.0	100.0	100.0	100

## Хөдөлмөрийн насны суралцагчдын бүтэц хүйсээр / хувиар /



Хөдөлмөрийн насны суралцагчид 2017 онд 6623 болж өмнөх оноос 1529 суралцагч буюу 30.0 хувиар нэмэгдсэн байна. Нийт суралцагчдын 51.8 хувийг эрэгтэй суралцагчид эзэлж өмнөх оныхоос 4.6 пунктээр нэмэгдсэн байна.

## Хөдөлмөрийн насны суралцагчдын тоо /оноор/




## Суурин болон хөдөлмөрийн насны хүн амын тоо /сумаар/

	Суурин хүн ам			Хөдөлмөрийн насны хүн ам	Суурин хүн амд	
	Бүгд	Үүнээс эмэгтэй	Хувь		Хөдөлмөрийн насны эзлэх %	Хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувийн жин
					Бүгд	
Алтай	4257	2101	49.4	2520	59	4.2
Алтанцөгц	2814	1415	50.3	1672	59	2.8
Баяннуур	4978	2423	48.7	2859	57	4.8
Бугат	3790	1864	49.2	2195	58	3.7
Булган	5183	2578	49.7	3052	59	5.1
Буянт	2846	1427	50.1	1711	60	2.9
Дэлүүн	7331	3721	50.8	4295	59	7.2
Ногооннуур	7976	3984	49.9	4502	56	7.5
Сагсай	5259	2643	50.3	2983	57	5.0
Толбо	4169	2078	49.8	2440	59	4.1
Улаанхус	8548	4270	50.0	4856	57	8.1
Цэнгэл	9322	4646	49.8	5351	57	9.0
Өлгий	35118	17748	50.5	21315	61	35.7
Дүн	101591	50898	50.1	59751	59	100.0

Хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувийн жин өндөр байгаа сумуудыг дурьдвал: Өлгий /35.7/, Цэнгэл /9.0/, Улаанхус /8.1/, Ногооннуур /7.5/, Дэлүүн /7.2/, Булган /5.1/ хувьтай байна. Хөдөлмөрийн насны хүн ам 2016 оноос 14.9 хувиар буюу 7734 хүнээр нэмэгдсэн байна.

## Хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь



## Хүн ам, хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	ХЭМЖИХ НЭГЖ	2016		2017		2017 % 2016
		Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	
Хүн амын тоо	тоо	99346	49808	101591	50898	102.3
15 ба түүнээс дээш насны хүн ам	тоо	62992	31854	66388	33499	105.4
Эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо	хүн	43940	20206	51973	23875	118.3
Ажиллагсдын тоо	хүн	39873	17851	46578	20480	116.8
Ажилгүй иргэдийн тоо	хүн	4067	2355	6570	3934	161.5
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо	тоо	1320	592	1207	513	91.4
Эдийн засгийн идэвхигүй хүн амын тоо	хүн	22571	13910	20676	11950	91.6
Ажиллах хүчний оролцооны түвшин	%	66.1	59.2	69.9	66.9	105.7
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	%	59.9	49.8	62.8	56.2	104.8
Ажилгүйдлийн түвшин	%	9.3	11.7	12.4	16.1	133.3

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn



Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтүүдээс харахад хөдөлмөрийн насны хүн амын 86.9 хувь нь эдийн засгийн идэвхитэй хүн байгаа ба тэдний 76.2 хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байна. Хүн амын 34.7 хувийг/35.3 мянга/ хүүхэд, 58.8 хувийг/ 59.7 мянга/ хөдөлмөрийн насны хүн ам, 5.3 хувийг /5.4 мянга/ хөдөлмөрийн нас хэтэрсэн ахмад настай хүмүүс эзэлж байна.

### Бүртгэлтэй ажилгүйчүүд, хамгийн их, бага он сар

Баян-Өлгий аймагт ажилгүйдлийн түвшин 2017 оны жилийн эцсийн байдлаар 12.4 хувь байгаа ба 2016 онтой харьцуулахад 3.1 пунктээр өссөн нь улсын дундажаас 5.1 пунктээр дээгүүр байгаа ба эдгээр үзүүлэлтүүд нь ажиллах хүчний түүвэр судалгааны тархаасан үр дүнгээр илэрхийлэгдсэн байна. Аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо

2017 оны 12 дугаар сарын эцэст 1207 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9.4 хувиар буюу 113 хүнээр буурсан байна. 2016 онд болж өнгөрсөн УИХ болон орон нутгийн сонгуулийн дараа бүтэцийн өөрчлөлт болон


бусад шалтгаанаар төрийн албан хаагч нар олоноор чөлөөлөгдөж ажилгүйчүүдийн эгнээнд шилжсэнээс ажилгүйчүүд өссөн. Хөдөлмөрийн зах зээлд 6570 хүн ажил идэвхитэй хайж эрж байгаа ба түүний таван хүн тутмын нэгэн буюу 18.8 хувь нь аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт хандаж албан ёсны бүртгэлтэй ажилгүйчүүдийн мэдээллийн санд бүртгүүлж байна.

Ажиллагчид, ажилгүй иргэд /хүйс, бүсээр /  
/АХС-ны үр дүнгээр /

Аймаг	Ажиллагчид / мян.хүн /				Ажилгүй иргэд							
	2014	2015	2016	2017	2014		2015		2016		2017	
					Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Бүгд	1110.7	1151.2	1147.8	1238.3	36970	20459	32788	17720	127807	48427	119092	49841
Баруун бүс	154.6	166.7	158.7	173.1	5636	3059	4597	2484	21826	10917	20851	11196
Баян-Өлгий	36.0	43.6	39.8	46.6	1445	768	1058	525	4067	2355	6570	3934
Говь-Алтай	23.9	25.1	23.7	25.9	912	509	644	336	2667	1150	2436	1220
Завхан	35.8	29.9	29.7	33.1	804	450	450	263	3839	2088	1507	898
Увс	29.2	35.2	31.3	33.3	1138	617	1163	569	5167	2552	4970	2650
Ховд	29.7	32.0	34.0	34.3	1337	715	1282	791	6056	2772	5368	2494
Баруун бүсд эзлэх хувь	23.3	26.2	25.1	27.0	25.6	25.1	23.0	21.1	18.6	21.6	31.5	35.1
Улсын дүнд эзлэх хувь	3.2	3.8	3.5	3.8	3.9	3.8	3.2	3.0	3.2	4.9	5.5	7.9

Судалгааны үр дүнгээр тооцсон аймгийн ажиллагчдын тоо өмнөх оныхоос 17.1 хувиар өсч, баруун бүсийн аймгуудаас бүс болон улсын дүнд эзлэх хувийн жин хамгийн өндөр аймгийн тоонд орж байна. Мөн бүртгэлтэй ажилгүйчүүдээр тооцсон хувийн жингээр бүсд эзлэх хувийн жингээр /31.5 / өндөр хувийн жинтэй аймгуудын тоонд орж байна.

Ажилгүй иргэдийн эзлэх хувь




2017 оны ажиллах хүчний судалгааны үр дүнгийн тооцоогоор ажиллагчдын тоо 46578 болж өмнөх оноос 16.8 хувь буюу 6705 хүнээр нэмэгдсэн байна. Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудад ажиллаж буй ажиллагчдын тоогоор баруун бүсийн аймгуудаас нэгдүгээрт тооцогдож байна. Ажиллагчдын тоогоор улсын дүнд 3.8 хувийг эзэлж өмнөх оноос 0.3 пунктээр нэмэгдсэн байна.


*Ажиллагчид /насны бүлэг, байршлаар/  
/АХС-ны үр дүнгээр/*

	Бүгд	Хүйс			Байршил					
		Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Хот			Хөдөө		
					Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
Бүгд	46,578	26,098	20,480	12,994	7,547	5,447	33,584	18,551	15,033	
Нас										
15 - 19	1,117	917	200	49	49		1,068	868	200	
20 - 24	4,386	2,731	1,655	1,271	824	447	3,115	1,907	1,208	
25 - 29	6,255	3,720	2,535	1,576	936	641	4,678	2,785	1,894	
30 - 34	7,175	3,854	3,321	1,848	1,165	683	5,326	2,689	2,638	
35 - 39	6,594	3,410	3,184	1,951	977	974	4,643	2,433	2,210	
40 - 44	7,478	4,003	3,475	2,423	1,433	990	5,055	2,570	2,485	
45 - 49	6,032	3,534	2,498	1,365	835	530	4,667	2,699	1,967	
50 - 54	3,740	1,824	1,916	1,030	436	594	2,709	1,388	1,321	
55 - 59	2,510	1,274	1,236	1,080	642	438	1,429	632	797	
60 - 64	987	625	362	253	151	102	734	474	260	
65 - 69	249	148	101	145	98	47	103	50	54	
70 +	57	57					57	57		

Ажиллах хүчний судалгааны үр дүнгээр тоцсон ажиллагчдыг байршлаар авч үзэхэд 46578 ажиллагчдын 72.1 хувь нь хөдөө, 27.9 хувь нь хот суурин газар амьдарч байна. Ажиллагчдын 56.0 хувийг эрэгтэйчүүд эзлэж байна.



Ажиллагчдыг насны бүтэцээр авч үзэхэд 16.1 хувийг 40-44 насныхан, 15.4 хувийг 30-34 насныхан, 13.4 хувийг 25-29 насныхан, 12.9 хувийг 45-49 насныхан эзлэж байна.




**Ажилгүй иргэд, хүйс, боловсролын түвшин, байршлаар**

	Хүйс			Байршил					
	Бүгд	Хүйс		Хот			Хөдөө		
		Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Хүйс		Бүгд	Хүйс	
					Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	6,570	2,636	3,934	3,247	1,485	1,762	3,322	1,151	2,172
Боловсролгүй	148	100	48	148	100	48			
Бага	285	47	238	47		47	238	47	191
Суурь	299	202	96	254	202	51	45		45
Бүрэн дунд	987	151	837	255	53	203	732	98	634
Техникийн болон мэргэжлийн	1,004	663	341	540	297	243	463	366	98
Тусгай мэргэжлийн дунд	152	45	107	50		50	102	45	57
Дипломын дээд болон бакалавр	3,640	1,428	2,212	1,954	833	1,121	1,686	595	1,091
Магистр	55		55				55		55

Боловсролын түвшнээр ажилгүй иргэдийг авч үзвэл тодорхой мэргэжил эзэмших түвшний буюу техникийн болон мэргэжлийн, бүрэн дунд, дээд боловсролтой ажилгүй иргэд нийт ажилгүй иргэдийн 86.0 хувь байгаа бол үлдсэн 14.0 хувь нь суурь түүнээс доош болон боловсролгүй иргэд байна.

## Ажилгүй иргэдийн боловсролын түвшин



## Ажиллагсад эдийн засгийн салбарын ангилалаар


Эдийн засгийн салбарууд	2013	2014	2015	2016	2017	$\frac{2017}{2016}$
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	17866	19189	19761	22672	21765	96.0
Уул уурхай	501	535	382	162	244	150.6
Боловсруулах үйлдвэр	554	664	1105	1402	1026	73.2
Цахилгаан, дулааны эрчим хүч, ус түгээх	323	335	346	349	230	65.9
Барилга	523	619	675	1876	2125	113.3
Бөөний ба жижиглэн худалдаа	2138	2450	2753	5482	7166	130.7
Зочид буудал, зоогийн газар	240	339	341	342	363	106.1
Тээвэр агуулах, холбоо	697	548	574	1898	2187	115.2
Санхүүгийн байгууллага	294	310	313	316	379	119.9
Үл хөтлөх хөрөнгө бизнес, түрээс	164	103	108	216	354	163.9
Төрийн захиргаа батлан хамгаалах	1455	1437	1403	2276	2006	88.1
Боловсрол	3692	3506	3686	3878	5521	142.4
Эрүүл мэнд	1115	1180	1233	1276	1637	128.3
НАА, үйлчилгээний бусад	244	173	170	730	481	65.9
Олон улсын байгууллагын болон хөлсний ажилчинтай өрхийн аж ахуй	49	38	42	89	65	73.0
<b>Дүн</b>	<b>29855</b>	<b>31426</b>	<b>32892</b>	<b>42964</b>	<b>45549</b>	<b>106.0</b>

## Ажиллагсадын бүтэц / хувиар/



Ажиллагчдын 47.8 хувийг хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад, 15.7 хувийг худалдааны салбарт ажиллагсад, 12.1 хувийг боловсролын салбарт ажиллагсад, 4.8 хувийг тээвэр агуулах, холбооны салбарт ажиллагсад, 4.7 хувийг барилгын салбарт ажиллагсад, 4.6 хувийг бусад салбарт ажиллагсад, 4.4 хувийг төр захиргаа, батлан хамгаалах салбарт ажиллагсад, 3.6 хувийг эрүүл мэндийн салбарт ажиллагсад, 2.3 хувийг боловсруулах үйлдвэрийн салбарт ажиллагсад тус тус эзлэж байна.


## Ажиллагсдын тоо / оноор /



## Ажиллах хүчний оролцооны түвшин ,бүс,хүйсээр

	2016			2017		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Баруун бүс	71.6	76.6	66.8	73.4	78.1	68.9
Баян-Өлгий	66.1	73.3	59.2	71.5	76.3	66.6
Говь-Алтай	74.4	80.4	68.7	75.3	78.6	72.1
Завхан	73.4	77.4	69.8	74.5	78.7	70.5
Увс	74.4	78.3	70.6	76.4	79.9	72.9
Ховд	72.5	75.9	69.1	71.	77.8	64.7

Ажиллах хүчний оролцооны түвшинг сүүлийн 2 жилээр авч үзэхэд бүсийн хэмжээнд ажиллах хүчний оролцооны түвшин 2017 онд 1.8 пунктээр, эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 1.5 пунктээр, манай аймгийн ажиллах хүчний оролцооны түвшин 5.4 пунктээр, эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 3.0 пунктээр илүү байгаа нь эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт эмэгтэйчүүдээс илүү байгааг харуулж байна. Бүсийн хэмжээнд эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт илүү байна.




Сумдын засаг даргын тамгын газар болон аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо жилийн эцсийн байдлаар 1207 болж өнгөрсөн оны мөн үеэс 113 хүнээр буюу 8.6 хувиар буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 42.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Ажилгүй иргэдийн 59.5 хувийг 15-34 насны залуучууд, үүний 29.7 хувийг дээд боловсролтой залуучууд эзэлж байна.

## Ажилгүйчүүдийн тоо

Сумын нэр	Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажилгүйчүүд									
	2013	2014	2015	2016	2017	2013	2014	2015	2016	2017
Алтай	14	35	8	14	8	7	15	3	6	3
Алтанцөгц	15	39	11	8	14	10	24	7	5	8
Баяннуур	18	45	7	20	20	7	16	2	8	7
Бугат	22	41	5	7	21	12	20	2	4	10
Булган	94	102	11	21	7	34	32	3	8	2
Буянт	12	57	15	18	18	8	37	9	12	11
Дэлүүн	18	94	17	35	35	5	23	4	10	8
Ногооннуур	44	48	15	28	28	14	14	4	9	6
Сагсай	23	41	19	24	24	9	15	7	10	8
Толбо	46	81	5	27	27	22	36	2	13	11
Улаанхус	23	42	20	17	17	6	9	4	4	4
Цэнгэл	79	69	12	25	25	17	14	2	5	5
Өлгий	890	833	979	1076	963	48	46	45	57	45
Цагааннуур	51					60				
Дүн	1349	1527	1124	1320	1207	26	28	19	25	20


## Бүртгэлтэй ажилгүйчүүдийн боловсролын түвшин / 2017 оны байдлаар /





Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүтэцээр авч үзвэл 46.6 хувийг 25-34 насныхан, 21.0 хувийг 35-44 насныхан, 12.9 хувийг 15-24 насныхан, 14.77 хувийг 45-60 насныхан эзлэж байна.

**Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажилгүй иргэд**



**Бүртгэлтэй ажилгүй иргэд /боловсролоор/**

Үзүүлэлтүүд	2014	2015	2016	2017	2017
					2016
Дээд	542	367	388	359	92.5
Тусгай дунд	145	117	119	91	76.5
Техник мэргэжлийн	87	55	53	44	83.0
Бүрэн дунд	565	474	638	628	98.4
Бүрэн бус дунд/суурь/	147	84	82	55	67.1
Бага	40	25	31	20	64.5
Боловсролгүй	8	2	9	10	111.1
<b>Бүгд</b>	<b>1534</b>	<b>1124</b>	<b>1320</b>	<b>1207</b>	<b>91.4</b>

## Шинэ ажлын байрны шилжилт хөдөлгөөн, салбараар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар	2015	2016	2017
<b>Бүгд</b>	<b>1551</b>	<b>1113</b>	<b>991</b>
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	203	168	37
Уул уурхайн салбар	9	31	
Боловсруулах үйлдвэр	477	374	129
Барилгын салбарт	88	91	55
Цахилгаан, эрчим хүч, дулаан усан хангамж			20
Бөөний ба жижиглэнгийн худалдаа	26	115	167
Зочид буудал зоогийн газар	362	21	37
Тээвэр, тээш хадгалалт, холбоо	46		
Санхүүгийн байгууллага	19	2	3
Боловсрол	3	192	212
Эрүүл мэнд	180	25	21
Төрийн удирдлага ба батлан хамгаалах, албан журам	27	9	139
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	43	2	156
Энгийн ажил мэргэжил	68	83	15
Ажлын байрны захиалга- Бүгд	1631	1061	1083
Ажилд зуучлагдан орсон-Бүгд	1212	940	997
Үүнээс: Менежер	20	6	45
Мэргэжилтэн болон туслах	140	200	345
Үйлчилгээний ажилтан	52	68	127
Үйлдвэрлэл, барилгын холбогдох ажилтан	297	184	202
Машин механизмын оператор	36	36	28
Хөдөө аж ахуйн ажилтан	60	28	0
Энгийн ажил мэргэжилтэн	600	413	234
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	7	5	16
Насны бүлэг: 15-24			239
25-34			441
35-44			201
45-60+			110


Эх үүсвэр: Хөдөлмөр халамж үйлчилгээний газар

## Шинэ ажлын байр 2017 он




Оны эхнээс 1083 хүний ажлын байрны захиалга ирсэнээс 991 хүн зуучлагдаж ажилд орсон 212 хүн буюу 21.3 хувь нь боловсролын салбарт, 16.8 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт, 15.7 хувь нь захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт, 13.0 хувь нь боловсруулах үйлдвэрт, 14.0 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагааны салбарт, 2.1 хувь нь эрүүл мэндийн салбарт, 3.7 хувь хөдөө аж ахуйн салбарт, 3.7 хувь нь зочид буудал, зоогийн газар, 5.5 хувь нь барилгын салбарт бий болсон байна.

### Ажлын байрны захиалга ба зуучлал



2017 онд 997 бүртгэлтэй ажилгүйчүүд ажилд зуучлагдан орсон байна. Хөдөлмөрийн хэлтэс болон сумдын Засаг даргын тамгын газарт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1207 байгаа нь 2016 оныхоос 8.6 хувиар буурч, 2017 онд 997 шинэ ажлын байр бий болсон байна. Засгийн газрын зүгээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжихдээ хууль эрх зүйн болон бусад таатай орчинг бүрдүүлэхэд анхаарч, Улсын Их Хурлаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг баталж, 2011 оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдөж байна. Энэ хуулийн гол агуулга нь сургалт, зөвлөлгөө, мэдээллээр хангах, мэргэжлийн сургалт, давтан сургалт явуулах, хувийн аж ахуй эрхлэх, хоршоодыг дэмжих, ажил олгогч нарыг дэмжих, нийтийг хамарсан түр хугацааны хөдөлмөр эрхлэх ажлыг зохион байгуулах зэрэгт чиглэж байна. Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалт, тусламж, хандив, бусад эх үүсвэрүүдээс бүрдэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг дээрх хуулийн дагуу байгуулан зарцуулж байна.

## Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн зарцуулалт / оноор /




2017 онд 9 төрлийн арга хэмжээ, төсөл, хөтөлбөр хэрэгжиж хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас зарцуулсан хөрөнгийн хэмжээ өмнөх оныхоос 64.3 хувиар өссөн байна.

## Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан хөрөнгө

Д/Д	Сангийн зарлагын зориулалт	2013	2014	2015	2016	2017
1	Иргэдэд ажил мэргэжлээ сонгох, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт	8653	9677.5	13500.0	7567.5	9450.0
2	Ажилд зуучлах	2223.8	5755.0	6000.0	3926.1	11760.0
3	Нийтийг хамарсан хөтөлбөр	153027.0	114199.8	80721.2	62318.4	
4	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ	32672.6	42757.2	68208.0		
5	Зээлийн хүүгийн нөхөн төлбөр	2608.8	1735.0	1899.0	1601.2	2000.0
6	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	8343.2	650.0	480.0		
7	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	80747.5	50020.0			
8	Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр	248066.6	125000.0	240840.0	97850.0	154015.0
9	Ажил олоход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ	1302.0	20000.0			
10	Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр		31515.0			
11	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр		29796.4	42200.0	40343.0	39592.0
12	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр		73000.0	93454.0	20270.0	50850.0
13	Бусад хөтөлбөр, төсөлийг санхүүлжүүлэх	38919.8	20000.0		4860.0	37700.0
14	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр			163839.1	144976	357906
15	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох ажлын байр хадгалах хөтөлбөр			35440.0	40576.0	33725.1
<b>Дүн</b>		<b>576564.3</b>	<b>524105.9</b>	<b>746581.3</b>	<b>424288.2</b>	<b>696998.1</b>

### Сангийн зарцуулалт /1 хүнд ногдох /




### Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаар үйлчилүүлсэн хүний тоо

Д/Д	Сангийн зарлагын зориулалт	2013	2014	2015	2016	2017
1	Иргэдэд ажил мэргэжлээ сонгох, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт	2244	2081	1953	864	1170
2	Ажилд зуучлах	1235	1375	1212	617	997
3	Нийтийг хамарсан ажил	1153	470	440	374	
4	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ	19	23	29		
5	Зээлийн хүүгийн нөхөн төлбөр	13	10	10	9	8
6	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	37	51	48		
7	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	458	203			
8	Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр	118	25	96	25	32
9	Ажил олоход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ	18	68			
10	Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр		116			
11	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр		55	52	101	120
12	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр		365	119	28	100
13	Бусад хөтөлбөр, төсөлийг санхүүжүүлэх	89	20		30	
14	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр			330	405	1095
15	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох ажлын байр хадгалах хөтөлбөр			144	97	304
<b>Дүн</b>		<b>5384</b>	<b>4862</b>	<b>4433</b>	<b>2550</b>	<b>3826</b>

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг дэмжих, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах, хөдөлмөрт бэлтгэх, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих, нийтийг хамарсан ажил зохион байгуулах, зээлийн хүүгийн нөхөн төлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг

дэмжих, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох ажлын байр хадгалах хөтөлбөрүүдийг санхүүлжүүлэхэд 697.0 сая төгрөг зарцуулагдаж, 3826 хүн хамарагдсан байна.

### Үйлчилүүлсэн хүний тоо



Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч болон төгсөгчдийн бүлэгт санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулан 15-24 насны мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагыг төгссөн төгсөгчдөөс ирүүлсэн төсөлийг шалгаруулан 14 төгсөгчид 42.0 сая төгрөг олгож 18 ажлын байр бий болгосон байна.

Д/Д	Сангийн зарлагын зориулалт	Нэг хүнд ногдох /мян.төг/				
		2013	2014	2015	2016	2017
1	Иргэдэд ажил мэргэжлээ сонгох, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт	3.9	4.7	6.9	8.8	8.1
2	Ажилд зуучлах	1.8	4.2	5.0	6.4	11.8
3	Нийтийг хамарсан ажил	132.7	243.0	183.5	166.6	
4	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ	1719.6	1859.0	2352.0		
5	Зээлийн хүүгийн нөхөн төлбөр	200.7	173.5	189.9	177.9	250.0
6	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	225.5	12.7	10		
7	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	176.3	246.4			
8	Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр	2102.3	5000	2508.8	3914.0	4813.0
9	Ажил олоход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ	72.3	294.1			
10	Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр		271.7			
11	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр		541.8	811.5	399.4	329.9
12	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр		200	785.3	723.9	508.5
13	Бусад хөтөлбөр, төсөлийг санхүүлжүүлэх	437.3	1000			
14	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр			496.5	358.0	326.9
15	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох ажлын байр хадгалах хөтөлбөр			246.1	418.3	110.9
<b>Дүн</b>		<b>107.1</b>	<b>107.8</b>	<b>168.4</b>	<b>166.4</b>	<b>182.2</b>

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар бий болсон ажлын байруудыг явуулж буй үйл ажиллагааны чиглэлээр авч үзэхэд дийлэх хувийг боловсуурах үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулагчид эзэлж байна. Дээрхи сангийн зарцуулалтаас үзэхэд хамрагдсан нэг иргэнд ажил мэргэжлээ сонгох, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд зориулж 8.1 мянган төгрөг, ажилд зуучлахад 11.8 мянган төгрөг, зээлийн хүүгийн нөхөн төлөх хөтөлбөрт 250.0 мянган төгрөг, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжихэд зориулан 4813.0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 329.9 мянган төгрөг, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 508.5 мянган төгрөг, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрт 326.9 мянган төгрөг, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох ажлын байр хадгалах хөтөлбөрт 110.9 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

### Дүгнэлт

1. Сүүлийн жилд боловсролын салбар, төрийн удирдлага ба батлан хамгаалах, цахилгаан, эрчим хүч, дулаан усан хангамжын салбарт ажил эрхлэгчдийн тоо нэмэгдэж байна.
2. Судалгааны үр дүнгээр тооцсон аймгийн ажиллагчдын тоо өмнөх оныхоос 17.1 хувиар өсч, баруун бүсийн аймгуудаас бүс болон улсын дүнд эзлэх хувийн жин хамгийн өндөр аймгийн тоонд орж байна. Мөн бүртгэлтэй ажилгүйчүүдээр тооцсон хувийн жингээр бүсэд эзлэх хувийн жингээр /31.5 / өндөр хувийн жинтэй аймгуудын тоонд орж байна.
3. Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэдийн 59.5 хувь нь 15-34 насны залуучууд байгаа нь хангалттай хөдөлмөрийн нөөц байгааг харуулж байна.
4. Ажлын байр шинээр бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татаж ажлын байр бий болгох, ажил олгогчийн зүгээс тухайн хүний нийгмийн баталгааг хангахад чиглэгдсэн тодорхой арга хэмжээнүүд авагдахгүй байна. Улмаар ажил хөдөлмөр эрхлээгүй хүний тоо бодитой буурахгүй жил бүр өсч нэмэгдэж байгаа ба шилжих хөдөлгөөнд оролцогчдын дийлэнх хувийг ажил хөдөлмөргүй иргэд эзэлж байна.
5. Ажиллах хүчний оролцооны түвшинг сүүлийн 2 жилээр авч үзэхэд манай аймгийн ажиллах хүчний оролцооны түвшин 5.4 пунктээр, эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 3.0 пунктээр илүү байгаа нь эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт эмэгтэйчүүдээс илүү байгааг харуулж байна. Бүсийн хэмжээнд эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт илүү байна.
6. 2017 онд хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах, ажилгүй иргэдийг дэмжих хөтөлбөр, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох ажлын байр хадлах хөтөлбөрүүдэд хамрагдагсадын тоо өмнөх оныхоос 2.7-3.6 дахин өссөн байна.
7. Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэдийг дэмжих хөтөлбөрт хамрагдагсадын 84.2 хувь нь боловсруулах үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчид эзэлж байна.

**Ашигласан ном, материалууд**

1. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2013, 2014,2015,2016 он
2. Хүн амын ажил эрхлэлтийн дотоод мэдээлэл 2013-2017 он
3. Баян-Өлгий аймгийн эдийн засаг нийгмийн байдлын эмхтгэл 2013,  
2013, 2014, 2015,2016,2017 он
- 4.Хөдөлмөр эрхлэлтийн албаны 2013,2014,2015,2016,  
2017 оны тайлан
5. Ажиллах хүчний судалгааны 2015,2016,2017 оны үр дүнгийн тайлан
6. Статистик мэдээллийн нэгдсэн сан: [www.1212.mn](http://www.1212.mn)
- 7.Баян-Өлгий аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт,  
нийлүүлэлтийн тоон болон чанарын судалгаа 2018 он